

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/77/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: А.Нанжидмаа Утас: 70453799, Цахим хаяг: Nanjidmaaa@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.БАТБАЯР ТАНАА

додд. о.д. 05 № МБА-додд.0177/СГА-тмз
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ



0200200338

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,209,300.00	2,501,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,209,300.00	2,501,300.00
35400	Хангамжийн материал	2,209,300.00	2,501,300.00
35470	Бусад хангамжийн материал	2,209,300.00	2,501,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,538,991.58	5,733,524.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,538,991.58	5,733,524.99
39200	Биет хөрөнгө	5,538,991.58	5,733,524.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,000,000.00	0.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-18,000,000.00	0.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	12,700,000.00	14,400,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,311,208.58	-9,411,208.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,659,200.00	4,659,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,508,999.84	-3,914,466.40
39300	Биет бус хөрөнгө	770,000.00	770,000.00
39301	Программ хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,748,291.58	8,234,824.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,748,291.58	8,234,824.99
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	312,114.01	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,346,177.57	8,234,824.99
51	Засгийн газрын хувь оролцоо	7,346,177.57	8,234,824.99
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51200	Хуримтлагдсан үр дүн	7,346,177.57	8,234,824.99
51210	Өмнөх үеийн үр дүн	7,346,177.57	7,346,177.57
51220	Тайлант үеийн үр дүн		798,647.42
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,346,177.57	8,234,824.99

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	168,013,600.00	169,536,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	168,013,600.00	169,536,500.00
1310	Орон нутгийн төсвөөс санхүүжих	168,013,600.00	169,536,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	168,013,600.00	169,536,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	169,617,333.56	168,737,852.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	169,617,333.56	168,737,852.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	133,059,557.08	136,738,735.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	105,112,122.17	98,611,075.90
210101	Үндсэн цалин	105,112,122.17	98,611,075.90
210105	Гэрээтийн цалин	928,610.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,259,542.36	12,823,828.58
210201	Тэтгэврийн даатгал	9,346,651.46	8,876,399.94
210202	Тэтгэмжийн даатгал	977,872.73	986,857.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	782,738.13	789,485.72
210204	Ажилгүйдлийн даатгал	195,834.59	197,371.44
210205	Эрүүл мэндийн даатгал	1,956,445.45	1,973,714.32
2104	Хангамж, бараа материалын зардал	8,283,580.50	8,496,404.24
210401	Бичиг хэрэг	1,492,190.00	1,432,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,709,080.50	3,440,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,390,090.00	1,738,484.24
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,692,220.00	1,885,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	969,500.00	6,531,500.00
210601	Багаж хэрэгсэл		1,031,500.00
210604	Урсгал засвар	969,500.00	5,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,382,043.00	7,447,500.00
210702	Дотоод албан томилолт	1,382,043.00	7,447,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	837,020.00	662,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	837,020.00	662,960.00
210802	Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	90,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	168,010.00	171,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,010.00	47,510.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,287,139.05	2,165,466.59
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	835,000.00	660,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,452,139.05	1,505,466.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,557,776.48	31,999,117.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,393,200.00	30,261,800.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,233,200.00	29,012,300.00
КТ(213303)	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,160,000.00	1,249,500.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох санхүүжилт	4,164,576.48	1,737,317.27
КТ213403)	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,164,576.48	1,737,317.27
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,603,733.56	798,647.42
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,603,733.56	798,647.42

2.3 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			9,281,044.41	9,281,044.41
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			9,281,044.41	9,281,044.41
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			41,995,107.87	41,995,107.87
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			7,436,177.57	7,436,177.57
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			7,436,177.57	7,436,177.57
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			7,436,177.57	7,436,177.57
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			798,647.42	798,647.42
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл			8,234,824.99	8,234,824.99

2.4 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	168,013,600.00	169,536,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	168,013,600.00	169,536,500.00
1310	Орон төсвөөс санхүүжих	168,013,600.00	169,536,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	168,013,600.00	169,536,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	168,013,600.00	169,536,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	168,013,600.00	169,536,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	131,115,823.52	137,537,382.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	100,878,007.48	98,923,189.91
210101	Үндсэн цалин	99,620,177.48	98,923,189.91
210105	Гэрээт ажлын хөлс	1,257,830.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,236,096.04	12,823,828.58
210201	Тэтгэврийн даатгал	9,323,205.14	8,876,399.94
210202	Тэтгэмжийн даатгал	977,872.73	986,857.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	782,738.13	789,485.72
210204	Ажилгүйдлийн даатгал	195,834.59	197,371.44
210205	Эрүүл мэндийн даатгал	1,956,445.45	1,973,714.32
2104	Хангамж, бараа материалын зардал	7,503,600.00	8,656,404.24
210401	Бичиг хэрэг	1,410,000.00	1,432,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,238,510.00	3,440,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,790,090.00	1,738,484.24
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,065,000.00	2,045,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,820,000.00	8,363,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,320,000.00	2,863,500.00
210602	Тавилга	350,000.00	
210604	Урсгал засвар	150,000.00	5,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,006,100.00	7,447,500.00
210702	Дотоод албан томилолт	4,006,100.00	7,447,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	837,020.00	662,960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	168,010.00	171,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,010.00	47,510.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	835,000.00	660,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	835,000.00	660,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,897,776.48	31,999,117.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,733,200.00	30,261,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,233,200.00	29,012,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,249,500.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох санхүүжилт	4,164,576.48	1,737,317.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,164,576.48	1,737,317.27

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
2200	Дотоод эх үүсвэрээр	0	0
223001	Бусад хөрөнгө	0	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	169,536,500.00	167,799,182.73	1,737,317.27	99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	169,536,500.00	167,799,182.73	1,737,317.27	99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	139,274,200.00	137,537,382.73	1,736,817.27	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	99,389,800.00	98,923,189.91	466,610.09	99.5
210101	Үндсэн цалин	99,389,800.00	98,923,189.91	466,610.09	99.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,417,600.00	8656404.24	593771.42	95.6
210201	Тэтгэврийн даатгал	9,442,000.00	8,876,399.94	565,600.06	94
210202	Тэтгэмжийн даатгал	993,900.00	986,587.16	7,042.84	99.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	795,100.00	789,485.72	5,614.28	99.3
210204	Ажилгүйдлийн даатгал	198,800.00	197,371.44	1,428.56	99.3
210205	Эрүүл мэндийн даатгал	1,987,800.00	1,973,714.32	14,085.68	99.3
2104	Хангамж, бараа материалын зардал	8,685,500.00	8,363,500.00	319,800.00	96.3
210401	Бичиг хэрэг	1,446,100.00	1,432,300.00	13,800.00	99
210402	Тээвэр, шатахуун	3,440,200.00	3,440,040.00	160.00	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,745,000.00	1,738,484.24	6,515.76	99.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,054,200.00	2,045,580.00	8,620.00	99.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,683,300.00	8,363,500.00	319,800.00	96.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,183,300.00	2,863,500.00	319,800.00	90
210604	Урсгал засвар				
2107	Томилолт, зочны зардал	5,500,000.00	5,500,000.00	0	
210702	Дотоод албан томилолт	7,520,600.00	7,447,500.00	73,100.00	99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,520,600.00	7,447,500.00	73,100.00	99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	694,100.00	662,960.00	31,140.00	95.5
210803	Даатгалын үйлчилгээ	324,000.00	324,000.00	0	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	173,100.00	171,450.00	1,650.00	99
210806	Мэдээлэл технологи	53,200.00	47,510.00	5,690.00	89.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,262,300.00	30,261,800.00	500.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,262,300.00	30,261,800.00	500.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,012,300.00	29,012,300.00	0.00	
	Олгосон санхүүжилт шилжүүлэг				
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	169,536,500.00	169,536,500.00		
13	ОРОН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	169,536,500.00	169,536,500.00		
132001	Орон төсвөөс санхүүжих	169,536,500.00	169,536,500.00		
	Байгууллагын тоо				
	Ажиллагсдын тоо	7.00	7.00	0.00	
	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	
	Гүйцэтгэх ажилтан	5.00	5.00	0.00	
	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	0.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Санхүүгийн хяналт аудитын алба нь төсвийн хөрөнгийг нийгмийн нийтлэг эрх ашгийн төлөө хууль тогтоомжийн хүрээнд үр ашигтай зарцуулдаг байдлыг хангуулах үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1,696.7 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 168,737.8 мянган төгрөгийн 1 хувь буюу 1,687.3 төгрөгөөс 80 хувиар тооцож 1,349.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 486.5 мянган төгрөгөөр буюу 6.28 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	0	0	
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	2,209.3	2,501.3	292.00
Үндсэн хөрөнгө	5,538.9	5,733.5	194.60
Нийт хөрөнгө	7,748.3	8,234.8	486.50
Өр төлбөр	312.1	0.00	-312.10
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,436.2	8,234.8	798.60
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,436.2	8,234.8	798.60

Бараа материалын дансны үлдэгдэл 2,501.3 мянган төгрөг болж 292.0 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал худалдан авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,538.9 мянган төгрөг болж 194.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь төсвийн хөрөнгөөр худалдан авалт хийсэн 1,700.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, балансаас балансад 18,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,234.8 мянган төгрөг болж 798.6 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө шилжүүлэх, тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,522.9 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 879.4 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна. Энэ нь засгийн газрын 43-р тогтоол мөрдөн ажилласантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 194,158.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 194,158.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 49,081.0 мянган төгрөгөөр бууруулж 145,077.5 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь улсын төсвийн орлого, зарлагатай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 169,536.5 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс 169,536.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 169,536.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 167,799.1 мянган төгрөгийг зарцуулж 1,737.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 167,799.1 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Санхүүгийн хяналт аудитын алба нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2020 оны санхүүгийн тайлангаар албан шаардлага өгсөн тул тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Ерөнхий чиглэлийн хавсралт 1 маягтаар 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад зөрчил илрээгүй болно.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 139, хугацаа хоцроож 10 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөрчил арилгах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамтаар ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 634.9 мянган алдаа зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоолоо.

4.2 Төлбөрийн акт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Санхүүгийн хяналт, аудитын

албаны даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/26, Б/27, 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн Б/20 дугаар тушаалуудыг хэрэгжүүлэхгүйгээр ур чадварын нэмэгдэл 315.9 мянган төгрөгийг дутуу, ээлжийн амралтын 319.0 мянган төгрөгийн илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн хянал, аудитын алба	1	634.9			1	634.9				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /А.НАНЖИДМАА/

2022 оны 02 сарын 24-ний өдөр